



ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ НЭР ДЭВШҮҮЛЭХ, ЗАЛГАМЖ ХАЛААНЫ
ЖУРАМ

Хувилбар №	2.0	Батлагдсан огноо	2023-06-28
------------	-----	------------------	------------



ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ НЭР ДЭВШҮҮЛЭХ, ЗАЛГАМЖ ХАЛААНЫ ЖУРАМ

Домэйн:	ТУЗ
Баримт бичиг баталсан:	Төлөөлөн удирдах зөвлөл
Хувилбар :	2.0
Шийдвэр	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 06 сарын 28-ний өдрийн BR 23/024 дугаар тогтоол

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ НЭР ДЭВШҮҮЛЭХ, ЗАЛГАМЖ ХАЛААНЫ ЖУРАМ

Засварын түүх

Доорх Засварын Түүхийн хүснэгтэд энэхүү баримт бичиг хэрэглэгдэж буй хугацаанд орсон бүх засварыг тэмдэглэнэ. Шинэчлэлтийг хийсэн огноо, хувилбарын дугаар, хийгдсэн өөрчлөлтүүдийн тайлбар, шалтгааны товч тайлбар, шинэчилсэн болон баталсан хүний нэр зэргийг хянах.

Хүчинтэй хугацаа	Шийдвэр # (хэрэв байгаа бол)	Хувилбар#	Өөрчлөлт Тайлбар Шалтгаан	Үүсгэсэн/ шинэчилсэн	Баталсан
2019..	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны ТУЗ-ийн BR 19/11 тоот тогтоол	1.0	Эхний хувилбар (англи) (Governance, Nomination and Compensation Committee Policy)	ХХН	Төлөөлөн удирдах зөвлөл
2023	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны ТУЗ-ийн BR 23/ 024 тоот тогтоол	2.0	Монгол орчуулга болон Компанийн засаглалын кодекс болон ТУЗ тус үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Төлөөлөн удирдах зөвлөл

Хувилбар №	2.0	Батлагдсан огноо	2023-06-28
------------	-----	------------------	------------

"Тэнгэр Даатгал" ХХК-ийн
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023-оны 06
дугаар сарын 28-ний өдрийн BR/024 тоот тогтоолын
Хавсралт №4



АГУУЛГА

НЭГ. ЗОРИЛГО.	4
ХОЁР. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ХЭМЖЭЭ, БҮРДЭЛ	4
ГУРАВ. ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙ ШАЛГУУР	5
ДӨРӨВ. ЗӨВЛӨЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ НЭР ДЭВШИГЧДИЙГ ТОГТООХ.....	6
ТАВ. ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ТОМИЛОЛТ, АЖЛЫН ХУГАЦАА.....	6
ЗУРГАА. ЦУНДХ-НЫ БҮРДЭЛ, ХУРЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....	7
ДОЛОО. ЦАЛИН, УРАМШУУЛАЛТАЙ ХОЛБООТОЙ ХАРИУЦЛАГА, ҮҮРЭГ.....	7
НАЙМ. ЦАЛИН УРАМШУУЛАЛ БА ДААТГАЛ	8

НЭГ. ЗОРИЛГО.

- 1.1 Тэнгэр даатгал ХХК ("Компани" гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ" эсхүл "Удирдах зөвлөл")-ийн Цалин, урамшуулал болон нэр дэвшүүлэх хороо ("ЦУНДХ") нь ТУЗ-ийн төлөөлөгчөөр дамжуулан, ТУЗ-ийн гишүүн болон компанийн Гүйцэтгэх удирдлагын багийн удирдлага, сонгон шалгаруулалт, нэр дэвшүүлэх, нөхөн олговор олгох асуудалд ТУЗ-д дэмжлэг үзүүлэх үндсэн үүрэгтэй. ЦУНДХ-ны үйл ажиллагааг энэхүү баримт бичигт тусгасан ЦУНДХ-ны бодлогоор зохицуулна.
- 1.2 ЦУНДХ нь ТУЗ-ийн шийдвэрээр тусдаа хороо байх шаардлаггүй гэж үзсэн эсвэл байгуулаагүй тохиолдолд тус хорооны үүрэг, зорилго, зохицуулалтыг ТУЗ хэрэгжүүлнэ.
- 1.3 ЦУНДХ-ны бодлогын зорилго нь Компанийн ТУЗ-ийг стратегийн удирдамжаар хангах үндсэн үүрэг, ТУЗ-ийн үндсэн үүрэг хариуцлагыг хангахуйц чанартай, зохих ур чадвар, чанаруудтай гишүүдээс бүрдүүлэхэд оршино. Компанийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн, хувьцаа эзэмшигчид болон сонирхогч талуудын ашиг сонирхлыг хамгаалах, дэмжих зорилгоор компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, хяналт тавих. Бодлого нь үйл явцыг тодорхойлж, Компанийн ТУЗ-ийг бүрдүүлэх, шинэчлэн байгуулах заавар, журам, Компанийн захирлаар ажиллах боломжит нэр дэвшигчдийг сонгон шалгаруулж, үнэлж, ТУЗ-д нэр дэвшүүлэх, дахин томилох зэргийг тусгасан болно.
- 1.4 Засаглалын хариуцлагын хувьд ЦУНДХ нь компанийн засаглалын асуудлаар Удирдах зөвлөлд туслах зорилготой бөгөөд Үүнд:
 - 1.4.1 Компанийн засаглалын үндсэн чиглэл, бодлогыг боловсруулж, зөвлөмж гаргах
 - 1.4.2 Удирдах зөвлөлийн үнэлгээ, түүний дотор ЦУНДХ-ийн жилийн үнэлгээнд хяналт тавих; болон
 - 1.4.3 Компанийн засаглалын асуудал болон ТУЗ-ийн үр дүнгийн асуудлаар ТУЗ-д зөвлөгөө өгөх, тэр дундаа ТУЗ болон ТУЗ-ийн хороодын бүтэц, бүрэлдэхүүний талаар зөвлөмж гаргах.
- 1.5 Цалин урамшууллын хариуцлагын хувьд ЦУНДХ нь цалин урамшууллын асуудлаар Удирдах зөвлөлд туслах зорилготой бөгөөд Үүнд:
 - 1.5.1 Гүйцэтгэх удирдлагын багийн цалин урамшууллын зохицуулалт, төлөвлөгөө, бодлого, хөтөлбөрийг үнэлэх, санал болгох, батлах, хянах;
 - 1.5.2 Гүйцэтгэх бус захирлын цалин урамшууллын талаар хянаж, үнэлж, Зөвлөлд зөвлөмж гаргах; болон
 - 1.5.3 Удирдах ажилтны цалин урамшуулалтай холбоотой үлдсэн үүргийн талаар Удирдах зөвлөлд зөвлөмж гаргах.
 - 1.5.4 Төлөөлөгч, зуучлагчын комиссын бүтэц, төлөвлөгөөг батлах.
- 1.6 ЦУНДХ-ны бодлого, Компанийн дүрэм эсхүл холбогдох хуулийн дагуу ЦУНДХ-ны зөвшөөрөл авахыг тусгайлан шаардаагүй бол Компанийн цалин урамшуулалын зохицуулалтыг хянах, батлах үүрэг нь Компанийн Гүйцэтгэх Удирдлагын багт хамаарна. Цалин урамшуулалтай холбоотой ЦУНДХ-ны хариуцлага, үүргийг энэхүү ЦУНДХ-ны бодлогын 7-р зүйлд нарийвчлан тусгасан болно.

ХОЁР. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ХЭМЖЭЭ, БҮРДЭЛ

Хувилбар №	2.0	Батлагдсан огноо	2023-06-28
------------	-----	------------------	------------

- 2.1 Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь олон төрлийн үзэл бодол, ур чадварыг нэгтгэсэн хэмжээ, бүрэлдэхүүнтэй байна. ТУЗ нь хувь нийлүүлэгчид, ашиг сонирхлын бүлгүүдийн бус харин компанийн ашиг сонирхлыг бүхэлд нь төлөөлж, үр дүнтэй шийдвэр гаргах үйл ажиллагааг хангана;
- 2.2 Компанийн ТУЗ таван гишүүнтэй байна. Таван гишүүний багадаа 1 гишүүн нь хараат бус гишүүн байна.
- 2.3 Хараат бус гишүүний байдлын үнэлгээг тухайн тохиолдол тус бүрт хийх бөгөөд тухайн гишүүн нь компанитай ямар ч холбоогүй гэдгийг багтаана.
- 2.4 ЦУНДХ нь Компанийн стратеги, зорилгод нийцүүлж ТУЗ-ийн бүтэц, хэмжээ, бүрэлдэхүүнийг тогтмол хянаж, дараахь зүйлсүүдийг баталгаажуулна. Үүнд:
- 2.4.1 Компанийн өнөөгийн болон шинээр гарч ирж буй асуудлуудын талаар зохих ойлголттой, шийдвэрлэх чадвартай байх;
- 2.4.2 Гүйцэтгэх болон гүйцэтгэх бус гишүүдийн зохистой харьцаатай байлгах;
- 2.4.3 Хүчтэй бие даасан үзэл бодол, дүгнэлт гаргах чадварыг харуулах;
- 2.4.4 Компанийн гүйцэтгэлийг сайжруулахад түлхэц болох;
- 2.4.5 Компанийн Гүйцэтгэх удирдлагын багийн гүйцэтгэлийг үр дүнтэй хянаж ба сорих.
- 2.5 ЦУНДХ нь ТУЗ-ийн үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор ТУЗ-ийн гишүүдийн ур чадвар, туршлага, мэдлэгийг үнэлнэ. ЦУНДХ нь ТУЗ-ийн боломжит нэр дэвшигчдийг сонгон шалгаруулах шалгуурыг боловсруулж, санал болгож буй өөрчлөлтийн талаар ТУЗ-д зөвлөмж гаргана.
- 2.6 ТУЗ-д сул орон тоо гарах бүрд ЦУНДХ нь сул орон тоог нөхөх зорилгоор нэг буюу түүнээс дээш нэр дэвшигчийг тодруулж, нэр дэвшигч тус бүрийг судалж, ТУЗ-д ажиллахад тохирох эсэхийг үнэлж, нэр дэвшигчийг ТУЗ-д санал болгох үүрэгтэй. ЦУНДХ нь хувьцаа эзэмшигчдийн жил бүрийн хурал бүр дээр нэр дэвшигчдийг ТУЗ-д сонгох, дахин сонгох санал гаргах үүрэгтэй.

ГУРАВ. ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙ ШАЛГУУР

- 3.1 ТУЗ-ийн даргаар ажиллах нэр дэвшигчийн ур чадварыг тодорхойлох, үнэлэхдээ дараах шалгуурыг харгалзан үзнэ. Үүнд:
- 3.1.1 Холбогдох бизнесийн туршлага, Компанийн бизнест хамаарах ур чадвар, өргөн сүлжээтэй байх. ТУЗ-ийн бусад гишүүдийг нөхөх чадвартай байх.
- 3.1.2 Олон улсын болон Монголын бизнесийн хүрээлэл болон нийгэмд бизнесийн болон ёс зүйн өндөр нэр хүндтэй байх. Мэргэжлийн үйл ажиллагаандаа байгуулсан амжилт болон компанийн үнэт зүйлд нийцсэн өөгүй шударга байх.
- 3.1.3 Өөрийн үүрэг, хариуцлагаа биелүүлэхэд хангалттай цаг гаргах чадвар, хүсэл эрмэлзэлтэй байх.
- 3.1.4 Монгол Улсын болон бусад гадаад улсын хууль тогтоомж, бизнесийн ёс зүй, бодлого, журмыг зөрчсөн тохиолдол бүртгэгдээгүй байх. Нэр дэвшигч нь Монгол Улсад болон бусад улсад төлбөрийн чадваргүй болох үйл ажилд хамрагдаагүй байх.

- 3.1.5 ТУЗ-ийн бусад гишүүдийн үнэлгээнд хамрагдсан байх, даатгалын зах зээлийн талаарх мэдлэгтэй байх. Тухайлбал зохицуулалтын орчин, шинэ бүтээгдэхүүн, актуар тооцоолол, хөрөнгө оруулалт, давхар даатгал, дотоод хяналт, мэдээллийн технологи, эрсдэлийн удирдлагын талаар хангалттай мэдлэгтэй байх.
- 3.1.6 Монголд оршин суудаг бол сайн.
- 3.1.7 Бусад Санхүүгийн Зохицуулах Хорооны тавьсан шаардлагад нийцсэн байх.
- 3.2 ТУЗ-ийн гишүүн эсвэл нэр дэвшигч бүр өөрийн хувийн ашиг сонирхол болон ТУЗ-ийн гишүүний үүрэг хариуцлагын хоорондох бодит болон болзошгүй буй зөрчил, түүнчлэн удирдах албан тушаалтнаар ажилладаг өөр компаниудад хүлээх үүрэг, үүргийн хоорондын зөрчилдөөнийг нэн даруй илчлэх ёстой. Ашиг сонирхлын зөрчлийг ил болгосны дараа ЦУНДХ зөвлөгөө өгөх бөгөөд зөрчилдөөний улмаас ТУЗ-өөс хасах шаардлагатай эсэх, нэр дэвшигчийн жагсаалтаас хасах, эсхүл ТУЗ-ийн гишүүн өөрөө хэлэлцэх асуудлын жагсаалтаас татгалзах боломжтой эсэхийг ТУЗ шийдвэрлэнэ.
- 3.3 Нэр дэвшигч нь Монгол Улсын даатгалын салбарын холбогдох хууль тогтоомж, тэр дундаа Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон журамд заасан тодорхой шалгуурыг хангасан байна.

ДӨРӨВ. ЗӨВЛӨЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ НЭР ДЭВШИГЧДИЙГ ТОГТООХ

- 4.1 ЦУНДХ нь ТУЗ-ийн гишүүн болох боломжтой нэр дэвшигчдийг тодорхойлохдоо хувьцаа эзэмшигчид, одоогийн ТУЗ-ийн гишүүд, удирдах албан тушаалтнуудын зөвлөмж, мэргэжлийн болон нийгмийн сүлжээний үйлчилгээ, цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглах боломжтой.
- 4.2 ЦУНДХ нь гуравдагч этгээдийг оролцуулж болно, жишээлбэл. Гүйцэтгэх албан тушаалтан хайх компани. Тус компани нь тохирох нэр дэвшигчдийг хайхад туслах эсхүл ТУЗ болон Компанийн Гүйцэтгэх удирдлагын багт нэр дэвшигчийн танилцуулга, туршлага, чадвартай холбоотой мэдээлэл цуглуулахад.
- 4.3 ЦУНДХ нь нэр дэвшигчийн шинж чанар, мэргэшлийг нарийвчлан судлах зэрэг зохистой гэж үзсэн үнэлгээний үйл явцад оролцох эрхтэй. ЦУНДХ болон ТУЗ-ийн нэг болон түүнээс дээш нэр дэвшигчтэй биечлэн ярилцлага хийх эрхтэй.
- 4.4 ЦУНДХ нь зөвлөмжийг боловсруулахдаа зөвхөн судалгааны болон үнэлгээний явцад гарсан дүгнэлт мөн төдийгүй ТУЗ-ийн одоогийн бүрэлдэхүүнийг харгалзан үзэх болно.
- Үүнд:
- 4.4.1 Удирдах зөвлөлийн гишүүдийн шинж чанар, ур чадвар.
- 4.4.2 Удирдах зөвлөлд нэмэлтээр шинж чанар, чадвар, мэргэшил.
- 4.4.3 Нэр дэвшигч эдгээр нэмэлт шинж чанар, чадвар, мэргэшлийг хангаж чадах эсэх.

ТАВ. ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ТОМИЛОЛТ, АЖЛЫН ХУГАЦАА

- 5.1 Санал болгож буй нэр дэвшигчдийн талаар ЦУНДХ зөвлөмж гаргах бөгөөд ТУЗ-ийн гишүүд нь ТУЗ-ийн тогтоолоор дүгнэлт гаргана. ТУЗ-ийн тогтоол нь Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар эсхүл хувьцаа эзэмшигчдийн засаглалын дагуу хүлээн зөвшөөрөгдсөн хэлбэрээр зөвшөөрөл авсан байх шаардлагатай. Энэхүү тогтоолд хувьцаа эзэмшигчдэд шийдвэр гаргахад шаардлагатай бүх мэдээллийг тусгах.

Хувилбар №	2.0	Батлагдсан огноо	2023-06-28
------------	-----	------------------	------------

- 5.2 ТУЗ-ийн гишүүд тус бүр хоёр жил шаталсан хугацаагаар ажиллах бөгөөд ТУЗ-ийн дарга бүр өөрийн залгамжлагчийг зохих ёсоор сонгогдож, мэргэшсэн болтол, эсхүл өмнө нь огцрох, огцруулах хүртэл бүрэн эрхээ хэрэгжүүлнэ. 5.3-т заасны дагуу зохих ёсоор улиран томилогдсон ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж болно.
- 5.3 ТУЗ-ийн даргыг автоматаар дахин хоёр жилийн хугацаатай дахин томилохгүй. ЦУНДХ нь хоёр жилийн хугацаа дуусахаас өмнө дахин томилох талаар зөвлөгөө өгөх бөгөөд энэхүү зөвлөгөө нь үргэлжлүүлэн хангалттай гүйцэтгэлтэй байхад оршино.

ЗУРГАА. ЦУНДХ-НЫ БҮРДЭЛ, ХУРЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 6.1 ЦУНДХ нь дор хаяж гурван гишүүнтэй байна. Бүх гишүүд нь ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх бөгөөд компанийн засаглал болон гүйцэтгэх удирдлагын мэдлэгтэй байна.
- 6.2 ЦУНДХ-ний бүх гишүүдийг ТУЗ-ийн зөвлөмжөөр томилно. Гишүүд тус бүр нь ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусах хүртэл ажиллах, мөн хугацаанаасаа өмнө нь огцрох, огцруулах тохиолдолд хамаарна. ТУЗ нь хорооны даргаар ажиллах Хорооны гишүүнийг томилж болно. Хэрэв ТУЗ нь даргыг томилоогүй бол Хорооны гишүүд олонхийн саналаар даргыг томилж болно. Дарга нь хорооны хуралдааны хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоож, хуралдааны явцыг удирдана. Хэрэв ийм томилгоо нь ТУЗ-ийн хорооны бусад үүрэгтэй зөрчилдөхгүй бол дарга нь “Хараат бус гишүүн” байх болно.
- 6.3 ЦУНДХ-ний аливаа гишүүнийг ТУЗ-ийн тогтоолоор хүссэн үедээ чөлөөлж, сольж болно. Хороонд сул орон тоо гарсан тохиолдолд үлдсэн гишүүд нь ирц бүрдтэл бүх бүрэн эрхээ хэрэгжүүлж болно.
- 6.4 ЦУНДХ нь хурлынхаа журмыг өөрөө тодорхойлох бөгөөд ЦУНДХ-ний аль ч гишүүн Хороог хуралдуулж болно. Хэрэв ЦУНДХ-ний хэлэлцэх асуудал нь компанийн гүйцэтгэх захирлын ажилд хамаарах бол ЦУНДХ нь түүний оролцоогүйгээр хуралдаж, зөвлөлдөх болно. ЦУНДХ хэлэлцэх асуудлын бүх асуудлаар зөвшилцөлд хүрэхийг хичээх болно. Хэрэв ийм зөвшилцөлд хүрч чадахгүй бол компанийн ТУЗ-ийн даргын дүгнэлт шийдвэрлэх болно.

ДОЛОО. ЦАЛИН, УРАМШУУЛАЛТАЙ ХОЛБООТОЙ ХАРИУЦЛАГА, ҮҮРЭГ

- 7.1 Цалин урамшуулалтай холбоотой ЦУНДХ-ний үүрэг нь ТУЗ-д дараахь байдлаар туслах явдал юм. Үүнд:
- 7.1.1 Гүйцэтгэх захирлыг оролцуулан компанийн Гүйцэтгэх удирдлагын багийг сонгох, томилох, дуусгавар болгох.
- 7.1.2 Гүйцэтгэх удирдлагын багийн залгамж халааны төлөвлөгөөг батлах, явцыг үнэлэх, боловсруулах.
- 7.1.3 Гүйцэтгэх захирлын эрх мэдэл, үүрэг, хариуцлагыг тодорхойлох зэрэг гүйцэтгэх удирдлагын багийн ажлын байрны тодорхойлолтыг үнэлэх, боловсруулах.

- 7.1.4 Гүйцэтгэх удирдлагын багийн цалин урамшуулал, тэтгэмжийн түвшинг үнэлэх, тогтоох, санхүүгийн болон санхүүгийн бус үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг хянаж, дүгнэлт гаргах.
- 7.1.5 Гүйцэтгэх удирдлагын багийн тэтгэмж, хяналтын төлбөрийн өөрчлөлт зэрэг хөдөлмөрийн гэрээ, ажлаас халагдсаны зохицуулалт, гэрээний зүйл заалтад оруулсан аливаа өөрчлөлтийг үнэлэх, дүгнэлт гаргах.
- 7.1.6 Компанийн гүйцэтгэх удирдлагын баг болон ТУЗ-ийн хоорондын харилцааг хянаж, ТУЗ-ийн гишүүдэд гүйцэтгэх удирдлагын багтай үр дүнтэй харилцах боломжийг олгох журмыг санал болгох.
- 7.2 ТУЗ-ийн дарга энэхүү журмын 7.1-ийн үүргийг хэрэв өөрөө хүсвэл дангаар гүйцэтгэж болно.

НАЙМ. ЦАЛИН УРАМШУУЛАЛ БА ДААТГАЛ

- 8.1 ТУЗ-ийн гишүүд оруулсан хувь нэмэр, үүрэг хариуцлагынх нь төлөө цалин урамшуулал авч болно.
- 8.2 ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулалын хэмжээг “Тэнгэр Даатгал” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтооно.
- 8.3 Удирдах зөвлөлийн гишүүн тус бүрд удирдах ажилтны хариуцлагын даатгалд хамрагдана. Энэхүү даатгалыг бусад нэр хүндтэй даатгалын компанид даатгуулна.
- 8.4 Даатгалтай холбоотой зардлыг “Тэнгэр Даатгал” ХХК хариуцах ба тухайн жилийн компанийн үйл ажиллагааны төсөвт тусгуулж хэрэгжүүлнэ.